



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/425

Булган сум

**Хүлэмж хүлээн авах
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/202 дугаар “Гэрээ байгуулах эрх олгох тухай” тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөө аж ахуйн салбар болон Хүлэмж-Хүнс төслийн тоног төхөөрөмж (Булган) хүлэмж нийлүүлэх тендер шалгаруулалтад шалгарсан “Сэхүүнчоно” ХХК-ийн нийлүүлж буй 32 мкв талбай бүхий 1000 ширхэг хүлэмжийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Жаргалсайхан (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Э.Уянга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Амаржаргал (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Л.Лхамаа (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Б.Одхүү (“Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга: Л.Наранчимэг (“Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ийн менежер)

2. Техникийн шаардлага хангасан барааг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэх, Орон нутгийн өмчид барааг хүлээн авсан тодорхойлолт, хөрөнгө бүртгэсэн маягтыг баталгаажуулж ажиллахыг ажлын хэсэг (Д.Жаргалсайхан)-т даалгасугай.

3. Хүлээн авсан барааг хадгалах, хамгаалах, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК (Б.Одхүү)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010555